



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/481

Алтай хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 32, 33 дугаар тогтоолын дагуу 2022 оны 08 дугаар сарын 05, 11-ний өдрүүдэд зохион байгуулах дахин дуудлагын худалдааг эрхлэн явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Өмчийн төлөөлөгч: Р.Наранбаатар (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Хөтлөгч: Р.Пүрэвдорж (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Б.Балдорж (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Дахин дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Р.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201391522